

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Хөвсгөл аймаг 2022 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарлаж нэрлэсэн жилийн нээлт, аймгийн “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2022 оны 03 дугаар 28-29-ний өдрүүдэд зохион байгуулаллаа.

Зөвлөгөөнд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Нарийн бичгийн дарга, сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, Соёлын төвийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн дарга, агентлаг, байгууллагын дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүд нийт 200 гаруй хүн оролцов.

Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан нэрлэсэн жилийн ажлын албан даалгаврыг төлөөлөгчдөөс төлөөлөл болгон Жаргалан, Галт сумын Засаг дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Хөдөлмөр халамжийн газрын дарга нарт гардуулав.

Хоёр. Хууль, эрх зүйн хүрээнд:

Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр :

Ханх сум, Жаргалант сум,Түнэл сум, Мөрөн сумдын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Үдийн хоол” хөтөлбөрийн шим тэжээлд хяналт шалгалтыг хийж ажиллаж гарсан зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, сургуулиудад үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжүүлэлтэд дотоод хяналтыг тогтмол хийж ажиллах чиглэлийг өгч ажиллаа. Мөн тендерээр үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа Танил жаргалан,Титаник компаниудад албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа.

Мөн Аймгийн 35 сургууль, 40 гаруй цэцэрлэгийн хоол зүйч, нярав, сургуулийн эмч 100 гаруй албан хаагчдад үдийн хоол хөтөлбөрийн хоолны шим тэжээлийн норм нормавид тавигдах стандар, шаардлагын талаар сургалтыг зохион байгуулж ажиллаа.

Аймгийн хэмжээнд хүнсний худалдааны бөөний үйл ажиллагаа явуулж буй 60 гаруй байгууллагад Киндер брэндийн герман улсад үйлдвэрлэсэн Киндер нэрийн бүтээгдэхүүнүүдэд тандалт судалгаа хийж, битүүмжилж ажиллав.

Байгаль орчны хяналтын чиглэлээр:

Хөвсгөл нуурын дагуу хэрэгжих Жанхай тойлогт чиглэлийн 38 км авто замын төслийн үйл ажиллагааны Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд хяналт хийж төсөл хэрэгжүүлэх явцад хөндөгдөх ойн санд учрах хохирол эрсдэлийг тооцож ажиллав.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:

МХЕГазрын даргын 2022-оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 1/63 удирдамжаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилт, тулгамдаж буй асуудалд тандалт судалгаа хийж байна.

Мөн МХЕГазрын даргын 2022 оны 1/91 дүгээр удирдамжийн хүрээнд туслах малчин, морь унаач хүүхдийн хөдөлмөрийн нөхцөлд хяналт шинжилгээг хийж ажиллаж байна.

Сургалт сурталчилгаа соён гэгээрүүлэх “Хүрч үйлчлэе” арга хэмжээний хүрээнд:

Хөвсгөл аймгийн хэмжээн хууль эрх зүйн мэдлэг олгох “Хүрч үйлчлэе” арга хэмжээг 03-р сарын нэгнээс эхлүүлээд ажиллаж байна тус арга хэмжээг 3 суманд зохион байгуулж 280 гаруй иргэд аж ахуйн нэгжийн төлөөлөлд сургалтыг хяналтын чиглэл бүрээр орж, үүсч болзошгүй эрсдэлийг хэрхэн бууруулах, бизнесийн байгууллага дотоод хяналтыг хэрхэн төлөвшүүлэх талаар зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаа.

Мөн төрийн байгууллага, иргэд, хувийн хэвшлээс гарч байгаа санал гомдлыг газар дээр нь шийдвэрлэж нийт 26 санал гомдол, хүсэлтийг шийдвэрлэв.

Онцгой байдлын чиглэлээр:

ОБЕГ-аас 2022 онд Хөвсгөл аймагт Бэлэн байдлын үзлэг зохион байгуулахтай холбогдуулан Аймаг, сумдын удирдах ажилтнууд, Аймгийн гамшгаас хамгаалах орон тооны бус албад, тусгай зориулалтын мэргэжлийн ангиуд, сумдын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, аж ахуйн нэгжийн удирдах бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийв.

Тогтвортой аялал жуулчлал төслийн хүрээнд аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэгт орж Хөвсгөл аймгийн Ханх сумын дахин төлөвлөлт, Ханх суманд шинээр байгуулагдах Эрэн хайх аврах бүлгийн барилга байгууламж засварлах чиглэлээр 2022 оны 03 дугаар сарын 06-09-ны өдрүүдэд ажиллав.

Аймгийн Прокурорын газрын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 436 дугаар албан бичгийн хүрээнд гал түймэр, гамшиг ослын талаар иргэд аж ахуй нэгж байгууллагатай холбоотой зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны талаар мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийн талаар санал боловсруулж хүргүүлэв.

Тариалан сум дахь Гал түймэр унтраах, аврах 46 дугаар ангийн шинэ барилгын зураг төслийг боловсруулах техникийн нөхцөл боловсруулж Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэв.

Төрийн цэргийн байгууллагуудын дунд зохион байгуулагдах Гар бөмбөгийн тэмцээнд ОББ-ын багт дэд ахлагч С.Ханджав оролцож байна.

Биеийн тамир, спортын зөвлөлөөс цэргийн биеийн тамирын стандартын дагуу шүүлэг 1 удаа, биеийн зохистой харьцааг 1 удаа тодорхойлж, анги салбарын дарга захирагч нарт холбогдох үүрэг чиглэлийг өглөө. Биеийн жингийн илүүдэлтэй алба хаагчдад сар бүр 3 кг-аас доошгүй жингээ бууруулах үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгаа:

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 112 дугаар албан бичгийн хүрээнд Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын шар усны үерийн нөхцөл байдлын дүгнэлт гаргаж тус сумын нэгдсэн хогийн цэгийг зөөвөрлөх ажилд шаардагдах 50.000.000 (Тавин сая) төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэв.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Барилгын хөгжлийн төв, Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгонд байрлах Ерөнхий боловсролын сургууль-89, сургуулийн өмнөх боловсролын байгууллага-47, сурагчдын дотуур байр-29 нийт 165 объектод хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Барилгын материал, мод модон эдлэлийн үйлдвэрлэлийн барилга, байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт”-ын удирдамжийн хүрээнд Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 16 ойн мэргэжлийн байгууллага, 41 барилгын материал худалдан борлуулах дэлгүүрт хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын хүрээнд 18 зөрчил илрүүлж 10 зөрчлийг газар дээр нь арилгуулж 8 зөрчлийг арилгуулахаар улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага-3, мэдэгдэл 2-ын тус тус үйлдэж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын баталсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлье” аяны хүрээнд хийх ажлын удирдамж, төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаа.

Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 3/294 дүгээр албан бичгийн хүрээнд “Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх аргачлал” цахим сургалтад хамрагдсан.

Хөвсгөл аймгийн иргэд олон нийтэд Онцгой байдлын газрын khu.nema.gov.mn сайт 15 удаа, Хөвсгөл Онцгой байдлын газар фейбүүк, фейж хуудсаар 75 удаа гамшиг ослоос урьдчилан сэргийлэх болон цаг үеийн мэдээ мэдээллийг дамжуулан ажиллаа.

“Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах” өдрийн хүрээнд мэдээллийг байгууллагын сайт болон орон нутгийн Далай ээж телевизэд 7 хоногийн 10 удаагийн давтамжтай хүргэсэн. Фэйж хуудсаар дамжуулан Зарлан мэдээллийн дохиогоор хэрхэн ажиллах агуулга бүхий 1 шторкийг бэлтгэсэн.

Орон нутгийн телевизэд 5 удаа, албаны сонин хэвлэлд 3 удаа, орон нутгийн урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг тус тус байршуулсан байна.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг Мөрөн сум, Дэлхийн Зөн ОУБ, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Насан туршийн боловсролын төв, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран нийт 75 удаа зохион байгуулсан.

Ангиллын сургалтыг Мөрөн сум, Хатгал тосгон, Галт сум, Тариалан сум, Цагаан-Уул сумдын ангиудын алба хаагчид үйлчлэх хүрээний сумдын Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажилтан алба хаагч, иргэдэд зохион байгуулж, аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадварт суралцсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 2/633 дугаар албан бичгийн хүрээнд “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээн”-ий удирдамжийн хүрээнд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг хүргүүлэн ажиллаж байна.

Гурав. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2022 оны 03-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас **11.0** тэрбум төгрөгний **1927** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2022 оны 02-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 7,280.3 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 7,824.1 сая төгрөг буюу 107.5% хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2022 оны 02-р сарын мэдээгээр Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 13,522.6 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 479,1 сая төгрөг нь татварын бус орлого буюу өөрийн орлогоос, 842,8 сая төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй хөрөнгө борлуулсан орлогоос, 3,476.3 сая төгрөг нь аймаг нийслэлээс авсан санхүүжилт, 11,761.1 сая төгрөг нь төсвөөс санхүүжих, 781.6 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 4,522,8 сая төгрөг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 13,522,6 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 5,658.6 мянган төгрөг буюу 41.8 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **3,793.5** сая төгрөг өмнөх сараас **42.3** сая төгрөгөөр өссөн.

Нийт өглөг **745.5** сая төгрөг өмнөх сараас **73.7** сая төгрөгөөр өссөн.

2021 оны 03 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 16683.9 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 5595.0 сая төгрөгийн, шимтгэлийн орлого 102.1 хувиар биелүүлсэн байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	6186.7	6009.4	97.1
Тэтгэмж	608.6	620.3	101.9
ҮОМШӨ	407.8	371.0	90.9
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	114.9	115.6	100.6
дүн	7318.0	7116.3	97.6

Тэтгэврийн даатгалын сангаас 21108 тэтгэвэр авагчид 29314.2 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 739 даатгуулагчдад 239.5 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 127 даатгуулагчдад 242.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 821.8 сая төгрөг байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

“Суурь судалгааны үр дүнд суралцагчийн сурлагын амжилтыг дэмжих сургалт”-ыг оношлох үнэлгээний 5, 9, 12 ангийн монгол хэл, математикийн хичээлийн үр дүнг танилцуулах, хоцрогдолтой агуулгыг сайжруулах, арга зүйн шинэ санаа боловсруулах, ЭЕШ-ын хичээлийн үр дүнд шинжилгээ хийх зорилгоор зохион байгууллаа.

“Хөх сувд-2022” мөсний баярын хүрээнд Монгол үндэсний хувцсыг эрхэмлэн дээдлэх, ур хийц, давтагдашгүй загварыг өвлүүлэх, хүүхэд залуусын хэрэглээнд хэвшүүлэх, иргэд жуулчдад сурталчлах зорилгоор “Хөх сувд-2022” мөсний баярын хүрээнд ЗДТГ, БШУГ, “Тойлог” жуулчны бааз хамтран амжилттай зохион байгууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн санаачилга, дэмжлэгээр хэрэгжиж буй “Шинэ ЭГЭЛ арга зүйгээр хичээлийн хоцрогдлыг арилгах нь” төслийн хүрээнд Хатгал тосгон, Ханх, Ренчинлхүмбэ сумдад математик, физикийн багш нар, математик, физикийн хичээлээр ЭЕШ өгөх сурагчдын төлөөлөл оролцсон сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг угтан Хөвсгөл аймгийн дүрслэх урлаг, технологийн уран бүтээлч багш нарын хамтарсан “ЦЭЦЭГСИЙН ДУУЛАЛ-2” үзэсгэлэн АРТ ГАЛЕРЕИД нээж, нийт 31 уран бүтээлч багш нарын 55 бүтээл дэлгэн гаргалаа.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хөрөнгө оруулалтын хэлтэс, Барилга хөгжлийн төв, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, ГХБХБГ, МХГ, ОБГ-ын төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсэг 23 сум, 1 тосгонд ажиллаж боловсролын салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалт, барилга байгууламжийн ашиглалт, хэрэглээ, шинээр баригдаж буй барилгын гүйцэтгэлийн явц, тулгамдаж буй асуудал, ус ариун цэврийн байгууламжийг шинэчлэх ажилтай танилцаж, нөхцөл байдлыг тодруулан, орон нутгийн удирдлага, гүйцэтгэгч компаниуд, мэргэжлийн байгууллагуудад зөвлөмж, чиглэл өгч ажиллан, он дамжин баригдаж буй боловсролын салбар дахь барилгуудын гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай барилгын ажлын явц, тулгамдаж байгаа асуудлын талаар тодруулга хийх уулзалтыг зохион байгууллаа.

Хөвсгөл аймгийн БШУГ-т ээлжит хичээлийн цахим контент бэлтгэх, цахим хичээлийн санг бүрдүүлэх, баяжуулах, сургалтад мэдээллийн технологийг бүрэн ашиглах, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын бэлэн байдлыг хангах зорилгоор БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар камер, компьютер, дэлгэц, микрофон, гэрэлтүүлэг, камерын хөл, sd card, чихэвч, флаш дискээс бүрдсэн 19 сая төгрөгийн үнэ бүхий мини студийн тоног төхөөрөмжийг нийлүүллээ.

Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан Дархан-Уул аймгийн “Монгол алт” ХК-ны захирал Ж.Мөнхтөрийн нэрэмжит хөдөө, орон нутгийн математикийн дунд ангийн багш нарын анхдугаар олимпиадад Хөвсгөл аймгийн багш нар амжилттай оролцлоо.

"Тогтвортой хөгжлийн боловсрол - II" төслийн Хөвсгөл аймгийн Техникийн зөвлөн зохицуулах орон нутгийн багаас Дэлхийн усны өдрийг угтан "Газар доорх ус" сэдвийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд зохион байгуулсан постер илтгэлийн уралдаанд 9 сургуулийн 12 бүтээл ирлээ.

СӨБ–ийн "Мэргэжлийн бүлэг-Хамтын хөгжил" удирдамжид үйл ажиллагааны 3 дугаар сард төлөвлөгдсөн сургалтууд зохион байгуулагдлаа. Сургалтын чиглүүлэгч багшаар СӨБС-ийн багш Ph.D О.Отгонцэцэг, СӨБС-ийн сургуулийн арга зүйн тэнхимийн эрхлэгч Ph.D Ж.Батдэлгэр нар ажиллаж Хөвсгөл аймагт үйл ажиллагаа эрхэлж буй 50 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нар бүрэн хамрагдлаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эрүүл мэндийн байгууллагуудын эх барих, эмэгтэйчүүд, нярайн эмч, эх баригч нарыг чадавхжуулах "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх,нярайн яаралтай тусламж"сургалтыг ЭМЯ, НҮБ-ын Хүн амын сан, АШУУИС, ЗДТГ, ЭМГ, НЭ зэрэг байгууллагууд хамтран зохион байгууллаа. Сургалтад Эрүүл мэндийн газар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн удирдлагууд, эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нар оролцсон. Тус сургалтыг зохион байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ЭМЯ, НҮБ-ын Хүн амын сангийн төлөөлөгч нар Алаг-Эрдэнэ, Хатгал сумын Эрүүл мэндийн төвийн Эх барихын тусламж үйлчилгээг хөдөө орон нутагт хэрхэн удирдан зохион байгуулж буй үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллалаа.

Монголын дүрс оношлогооны нийгэмлэг, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Дүрс оношлогооны эмчтэй хамтран, "Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь" төслийн хүрээнд Хэвлийн хөндийн хэт авиан оношлогооны чиг баримжаа олгох чиглүүлэх сургалтыг зохион байгуулав.

Хөвсгөл аймгийн ЭМГ-ын дарга М.Үүрийнбаяр, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Г.Оюунжаргал нар УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалантай уулзаж Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, "Элэг бүтэн Хөвсгөлчүүд" хөтөлбөрийн хүрээнд хавдрын эрт илрүүлгийн ажлыг эрчимжүүлж, иргэддээ хэрхэн чирэгдэлгүй, зөв зохион байгуулалттай ажиллах талаар санал солилцлоо.

Шастины нэрэмжит Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг болон Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Хамтын ажиллагааны хүрээнд тусламж үйлчилгээг оновчтой үр дүнтэй зохион байгуулах эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллахаар боллоо. Мөн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгийн захирал М.Адилсайхантай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын номхон далайн бүсийн мэргэжилтэн Manilay Phengxay, ДЭМБ-ын мэргэжилтнүүд болон Эрүүл мэндийн сайдын халдварт өвчний асуудал хариуцсан зөвлөх А.Амбасэлмаа, ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгжийн дарга А.Бурмаа нар Хөвсгөл аймгийн Томуугийн харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгж дээр ажиллаж байна.

"ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРТЭЧ МОНГОЛ" аяны хүрээнд зохион байгуулах "ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРҮҮЛ ИРГЭНТЭЙ ХӨВСГӨЛЧҮҮД" аянд Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төв, хувийн эмнэлгүүд, Өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн эмнэлгүүдийн төлөөллүүд нэгдэн оролцлоо.

Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч нарт "Ажлын байрны ёс зүй, сувилахуйн тусламжийн чанар, аюулгүй байдал", цахим сувилгааны түүх хөтлөлт багц цагийн сургалтыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн сайд С.Энхболд Хөвсгөл аймагт ажиллаж Эрүүл мэндийн газар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн төлөөллүүдтэй уулзан, Сүрьеэгийн үндэсний зөвлөгөөнийг Хөвсгөл аймагт зохион байгууллаа. Зөвлөгөөнд Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал Ц.Билэгтсайхан болон бусад албаны төлөөлөгч, Ховд, Завхан аймгийн орон нутгийн удирдлагууд болон эрүүл мэндийн салбарын төлөөлөгч нар оролцлоо. "Сүрьеэгүй ирээдүйн төлөө хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлье" зөвлөгөөн үндэсний хэмжээнд Улаанбаатар хотод танхимаар зохион байгуулагдаж, бусад аймгууд цахимаар холбогдлоо. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр – 5" төслийн хүрээнд 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийн барилгын их засвар, тоног төхөөрөмж ханган нийлүүлэгдэж, шинэчлэл хийгдсэн. Уг нээлтийн ёслолд ЭМ-н сайд С.Энхболд, эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн зохицуулагч А.Мөнхтайван болон орон нутгийн удирдлагууд оролцлоо.

Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах" нэрлэсэн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө танилцууллаа. Зөвлөгөөнд 23 сум, нэг тосгон, өрхийн эрүүл мэндийн төв зэрэг эмч эмнэлгийн 80 гаруй ажилчид хамрагдлаа. Тус зөвлөгөөний үеэр 2021 оны ажлын үр дүн, амжилтуудаа байгууллага хоорондоо сурталчлан таниулж, дүгнэн хэлэлцлээ.

ДЭМБ-ын санхүүжилтээр Анхан шатны байгууллагуудын дарга нарт "Удирдлагын манлайлал, цагийн менежмент" сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулж сум, өрхийн ЭМБ-уудын 28 дарга нар оролцлоо.

Монголын Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо, Хөвсгөл аймгийн Сумын эмч, мэргэжилтнүүдийн салбар хороо хамтран 23 сумын Эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт "Эрүүл мэндийн төвүүдийн менежментийг сайжруулах нь" сэдэвт сургалт зохион байгуулсан.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаалаар баталсан эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл ажлын байр хөдөлгөөн өрнүүлэх шинэчилсэн журмын хэрэгжилтийг ханган ажилласан.

Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч нарт "Ажлын байрны ёс зүй, сувилахуйн тусламжийн чанар, аюулгүй байдал", цахим сувилгааны түүх хөтлөлт багц цагийн сургалтыг УНТЭ-ийн арга зүйч Сувилахуйн ухааны магистр С.Наранцэцэг, СЭМҮТ-ийн Сувиалхуйн албаны дарга Сувилахуйн ухааны магистр О.Оюунтөгс нар, ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн алба, арга зүйч, нарийн мэргэжлийн сувилагч, мэргэжилтнүүд "Яаралтай тусламж", "Мэдрэлийн өвчний сувилахуйн тусламж", "Хүүхдийн өвчний сувилахуйн тусламж", хүчилтөрөгч эмчилгээ, зүрхний бичлэг хийх, шээлгүүр тавих арга зүй, ходоодонд зонд тавих арга зүйн

онолын болон гардан үйлдлийн сургалтыг зохион байгуулж, онолын мэдлэгийг үнэллээ.

Эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан тэмцээнд 23 сумаас шигшигдэж шалгарсан эрэгтэй 6 баг тамирчид, эмэгтэй 10 баг тамирчид, аймгийн Эрүүл мэндийн газраас спортын төрөл тус бүрд 1 баг, аймгийн нэгдсэн эмнэлгээс 3 баг, Зоонозын өвчин судлалын төв, Өрхийн эмнэлгүүдийн хамтарсан баг, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эм холбооны хамтарсан баг, Сургууль, цэцэрлэг, бусад байгууллагуудад ажиллаж байгаа эмч сувилагч нараас бүрдсэн баг тамирчид буюу нийт 600 гаруй тамирчид 15 байр 57 медалийн төлөө хурд хүч авхаалж самбаагаа дайчлан өрсөлдлөө.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

WAIS программаар 2022 оны 3 дугаар сард 6897 иргэнд 160 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг олгосон. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ehalamj.mn-ээр 14174 иргэнд 1.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон.

Хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд 37 иргэнийг ажлын байранд зуучилсан. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын LMIS-д 337 иргэнийг идэвхтэй ажил хайгчаар бүртгэсэн. Аймгийн хэмжээнд 72 ажлын байр бий болсон. Үүнээс 52 нь байнгын, 5 нь улирлын, 30 түр ажлын байр бий болсон.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдээс эхний улиралд 118 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. 2022 онд онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 7 хөтөлбөр хэрэгжих бөгөөд 2,2 тэрбум төгрөг төсөвлөгдөж ирсэн.

Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Хөвсгөл далайн зүүн эрэгт байрлах Ахмадын амралтын газрын үйл ажиллагааг эхлүүлэв. Мөн тус амралтын газарт ажиллах гэрээт албан хаагчдыг сонгон шалгаруулж хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

“Хөх сувд-2022” мөсний баярын нээлтэд зориулсан хүндэтгэлийн тоглолтыг аймгийн ХДТ-аас зохион байгуулсан ба, Хөвсгөл нутгийн олон ястны язгуур урлагийн үзүүлбэрүүд нь үзэгчдийн сонирхлыг ихээхэн татаж чадлаа. Хүндэтгэлийн тоглолтод нийт 48 уран бүтээлчид оролцсон. Цаатан бүжгийн эмэгтэй 7ш хувцас, эрэгтэй 6 хос хувцас, Этник хамтлагийн хөгжимчдийн эрэгтэй 5 хос /дээл, цамц, бүс/, эмэгтэй 3 хос / дээл, ууж, бүс, лоовууз малгай шанхтайгаа, 10ш үстэй хүрэм. Дархад, Цаатан, Урианхай, Халх, Буриад, Хотгойд ястны дээл 10ш, үстэй малгай 3 ш хийгдэж нийт шинээр 44 ш хувцас урлагдсан байна.

Хөгжимт драмын театрын уран бүтээлчид “Эгшигт бүүвэй” тоглолтыг эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр Бүрэнтогтох суманд зохион байгуулсан, мөн Монгол цэргийн өдрийг тохиолдуулан МУ-ын Баатар Л.Даваадоржийн нэрэмжит Хилийн цэргийн 0257-р анги, Агаарын 321 – р анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран “Манай цэргийн аялгуу” урлагийн тоглолтыг хүргэлээ.

Нийтийн номын сангаас 1186 уншигчдад шинээр карт нээж, 4458 үйлчлүүлэгчдэд 6863 ширхэг ном олгож үйлчилсэн. Дэлхийн яруу найргийн өдрөөр “Орчин үеийн яруу найраг”, “Эмэгтэйчүүд айл гэрийн аж жаргал”, “Хөвсгөлийн ган үзэгтнүүд”, дэлхийн театрын өдөрт зориулан “Дэлхийн сонгодгууд” сэдвээр тус тус үзэсгэлэн гаргалаа.

Мөрөн Гурван-Эрдэнэ ЕБС-д зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж ажилтан албан хаагч болон багш нар, хүүхдүүдэд уншигчийн карт нээж үйлчиллээ. Шинээр ирсэн номуудаар үзэсгэлэн гаргаж, "А-Я хүртэлх аялал " , "Цагаан дарь эхийн" домгоор чанга уншлага хийлээ. Мөн сургуулийн номын санчид Lib4u программын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. 216 хүүхдүүдэд уншигчийн карт нээж үйлчилсэн. “Монгол ухаан” булангаараа хүүхэд багачууддаа зориулан оньсого, зүйр цэцэн үгийг цувралаар оруулдаг. Энэ удаа зүйр цэцэн үгс оруулж хүүхэд багачуудад сонирхууллаа.

Дэлхийн яруу найргийн өдрөөр Нийтийн номын сангийн хамт олон Аймгийн Утга зохиолын нэгдлийн уран бүтээлчдийг хүлээн авч,"Гэгээн цаг" чөлөөт уулзалт ярицлага зохион байгууллаа.

Тееп шийдэл төслийн зохицуулагчтай ярилцаж, уншигчидтай уулзалт хийн төслийн талаарх мэдээллийг авсан.

Хүүхдийн номын өдрийг тохиолдуулан Хүүхдийн зохиолч Жамбын Дашдондогийн “Цэдэндамбыг мангас идчихлээ” зохиолыг ДМЦС-ийн сурагч Ш.Урангоогийн уншсанаар хүргэлээ.

Шинжлэх Ухаан Академийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн, Соёлын өвийн Үндэсний төвийн хамтарсан судалгааны багийн соёлын биет болон биет бус өвийн судалгааны ажилд хамтран ажиллалаа.

ХӨХ СУВД-2022 мөсний баярт зориулсан "Нүүдэлчний өвөл" түр үзэсгэлэнг гаргаж 200 гаруй хүн үзэж сонирхлоо.

Жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй удирдагчдын сонгон шалгаруулалтад 19 аймгийн 170 гаруй байгууллагын 1800 гаруй албан хаагч хамрагдаж, аймаг бүрт гурван салбараар жендэрийн мэдрэмжтэй 29 удирдагч сонгон шалгаруулахад аймгийн Орон нутгийг судлах музейн захирал Х.Рагчаа шалгарлаа.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн дундад зууны салбарын ЭША доктор С.Хүрэлсүх, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн чулуун зэвсгийн судалгааны

салбарын ЭШТА доктор Ц.Болорбат нар Хөвсгөл аймгийн сумдын соёлын өвийн ажилтнуудад цахим сургалт зохион байгууллаа.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого Их-Уул, Тариалан, Рашаант, Тосонцэнгэл сумдад явагдав.

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан "Хөх сувд" мөсний баярын хүрээнд анх удаа "Хөх цом" яруу найргийн наадмыг аймгийн Соёл урлагийн газар, Нийтийн номын сан хамтран зохион байгууллаа. Яруу найргийн наадмыг СГЗ Чой.Давгадорж, зохиолч, яруу найрагч Ж.Даваадамдин зохиолч, Ц.Ганболд, П.Майнбаяр нар шүүн тунгааж, "Алагцар" жуулчны бааз, Хатгал тосгоны Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөл дэмжлэг үзүүлэн ивээн тэтгэж оролцлоо

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ЧИГЛЭЛЭЭР:

Газрын дэргэдэх "Нэг цэгийн үйлчилгээний төв"-өөр 2022 оны 3 дугаар сарын байдлаар нийт 72 хүн үйлчлүүлсэн байна. Үүнээс хүүхэд 23 (эрэгтэй 7, эмэгтэй 16), насанд хүрэгч 49 (эрэгтэй 13, эмэгтэй 36) байна.

2021 оны үйл ажиллагааг нь дүгнэж, шилдэг хамтарсан багаар 3 сумыг, шилдэг эцэг, эхийн зөвлөлөөр 3 байгууллагыг шалгаруулан нийт 2,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Хөгжлийн бэршээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах салбар комиссын хурлаар 19 хүүхдийг хэлэлцэж шийдвэрлэн ажилласан байна.

Цахимд тавигдсан мэдээллийн дагуу Хүүхдийн эрхийн улсын байцаагч нар Жаргалант суманд ажиллаж, холбогдох байгууллагын төлөөлөл хүмүүстэй уулзалт хийн асуудлыг тодруулан, аймгийн хяналтын Прокурорт танилцуулж 9 хүний мэдүүлэг, тайлбарыг хүргүүлээд байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хуралдаж, шинэлэгдсэн журамтай гишүүд танилцан 5 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Өсвөрийн шатарчдын "Цодгор хүү-2022" аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 5, 7, 9, 11 хүртэлх насанд эмэгтэй, эрэгтэй гэсэн нийт 8 насны ангиллаар зохион байгуулж, 6 цэцэрлэг, 2 шатрын холбоо болон клуб, 8 сумын ЕБС, Мөрөн сумын 9 ЕБС-ийн нийт 208 хүүхэд багачууд оролцон, 8 хүүхэд улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авлаа.

"Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо" үндэсний чуулганаас гарах шийдвэрт санал, зөвлөмж хүргүүлэхэд бусдын санаа бодлыг сонсон нэгтгэх зорилгоор 20 эрчүүдийг хамруулан дэд хэлэлцүүлгийг зохион байгуулан 5 саналыг хүргүүлэн ажиллаж, чуулганд аймгаа төлөөлж 5 оролцогч оролцсон байна.

Тариалан, Түнэл, Тосонцэнгэл, Мөрөн сумын 137 залуучууд, 150 эрчүүд, 30 гэр бүл, 25 багш ажилтнуудад хүүхдийн нас сэтгэхүйн хөгжлийн онцлогт тохирсон хүмүүжлийн эерэг аргыг өдөр тутамдаа хэрэгжүүлэх, эцэг эхчүүд өөрсдийн мэдлэг, хандлагыг эергээр өөрчлөх нийгмийн хэрэгцээ шаардлага бий болсон талаарх мэдээллийг хүргэсэн байна.

“Хөх сувд-2022” мөсний баярын нэгдсэн хөтөлбөрийн дагуу 2 төрлийн тэмцээнийг зохион байгуулж, 12 гэр бүл, 192 залуучуудыг хамруулан 3 гэр бүл, 4 багийг шалгаруулан өргөмжлөл, үнэ бүхий зүйл олголоо. Мөн мөсний баяраар “Нэгдүгээрт хүүхэд” уриалгатайгаар хүүхэд хамгааллын нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хүүхдээ эрсдэлээс хамгаалан аюулгүй аялах 6 төрлийн зөвлөмж, мэдээллийг 700 гаруй хүнд хүргэн ажиллав.

Байгууллагын 3 албан хаагч 4 төрлийн сургалтад хамрагдаж, хувь хүний хөгжил, зорилтод бүлгийн залуучуудтай ажиллах арга зүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр чадавхжсан байна.

Жендэрийн үндэсний хорооноос жил бүр зохион байгуулдаг “Харилцан хүндэтгэе” сарын аяныг удирдамж, төлөвлөгөө гарган амжилттай хэрэгжүүлж, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг үндэсний хороонд хүргүүлсэн.

Зургаа мал аж ахуй, газар тариалан, хаваржилтийн талаар:

Мал төллөлт оны эхний 2632722 толгой хээлтэгч мал төллөхөөс нийт 168662 толгой хээлтэгч төллөсөн үүнээс ингэ 2, гүү 714, үнээ 5693, эм хонь 107150, эм ямаа 55103 мал төллөж байна. Нийт 166626 толгой төл бойжиж байгаагаас ботго 2, унага 689, тугал 5623, хурга 106141, ишиг 54171 толгой байна. Төлөлтийн хувь 8.1 хувьтай, төл бойжилт 99.1хувьтай байна. Оны эхнээс 3532 толгой том мал хорогдож үүнээс: адуу 198, үхэр 377, хонь 1544, ямаа 1413 мал хорогдож оны эхний нийт малаас 0.06 хувь нь хорогдсон байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Шүлхий өвчний сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн А/41 дүгээр тушаалын дагуу орон нутагтаа яаралтай дархлаажуулалтын ажлыг шүлхий өвчний халдварын тохиолдол бүртгэгдсэн, эрсдэл өндөртэй 15 суманд зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын А/74 захирамж, Мал эмнэлгийн газрын даргын А/07 дугаар тушаалын дагуу ажлын удирдамж боловсруулан сумдад хүргүүлсэн.

Байгаль орчин:

Хөх сувд 2022 мөсний баяр 20 дахь жилдээ 2022 оны 03 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд Хатгал тосгоны Хүй толгойд Цэнгэгээс цэнгэг, Цэврээс цэвэр” уриан дор зохион байгуулагдлаа. Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны А/565 захирамжаар “Мөсний баярыг зохион байгуулах ажлын хэсэг болон зохион

байгуулалтын 6 дэд ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааг зохион байгууллаа. Мөсний баярын үеэр олон нийтийг хамарсан 16 тэмцээн уралдаан, 6 соёл урлагийн арга хэмжээ хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан.

Мөсний баярт 1858 тээврийн хэрэгсэл, 11,253 дотоодын жуулчид Улаанбаатар, Дархан-Уул, Орхон,Архангай,Баянхонгор,Сэлэнгэ, Булган, Өмнөговь, Увс, Завхан Хэнтий, Увс, Төв зэрэг 14 аймаг хотоос ирж оролцсон. Гадаад орнуудаас Солонгос,Франц, Герман,Их Британи улсаас 23 жуулчид хүрэлцэн ирсэн. Зохион байгуулалтын арга хэмжээнд 382 хүн ажиллаж, уралдаан тэмцээнүүдэд 2000 хүн оролцож авьяас билэг, авхаалж самбаагаа сорилоо. Арга хэмжээний үеэр Халуун хоол цайгаар үйлчлэх 58 цэг, гэр гуанз, хүнс болон бараа, гар урлал бэлэг дурсгалын худалдаа эрхэлдэг 60 иргэн, тоглоомын үйлчилгээ 7 нийт 125 цэг үйл ажиллагаа явууллаа.

Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр ХНБЦГ-ын орчны бүсийн 6 сум, УБ хот, Орхон, Сэлэнгэ, Замын – Үүд, Ховд аймаг, манай аймгийн Мөрөн, Арбулаг, Рашаант, Хатгал тосгоны иргэд болон 15 төрийн байгууллага үйлчилгээ явуулж, 49 жуулчны бааз, гэр буудал жуулчдыг хүлээн авч байрлуулсан. Мөсний баяр зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн бичиж аймгийн ЗДТГ, Тогтвортой аялал жуулчлал төслийн нэгжид хүргүүлсэн.

Аялал жуулчлалын менежментийг сайжруулах хөтөлбөрийг боловсруулан ажлын хэсэгт танилцуулан, төсөлд санал авахаар холбогдох газруудад /Соёл урлагийн газар, Музей, ТХГ, Аялал жуулчлалын холбоо/- хүргүүлээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа “Соёмбо” цэцэрлэгт хүрээлэнд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын мэдээллийг бэлтгэж БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газарт хүргүүлэв.

Жаргалант сумын 5-р багт байрлах “Лавайн нуур” ХХК-ийн “Идэрийн Ундарга” шатахуун түгээх станцын байгаль орчны ерөнхий үнэлгээ гаргаж ажилласан.

Эрдэнэбулган сумын хогийн цэг халианд автаж Эгийн голд бохирдол үүсэх нөхцөл байдал үүссэн тул Эрдэнэбулган сумын хогийн цэгийг сумын төвөөс 4 км газарт нүүлгэн шилжүүлэх, хогийн цэг орчимд хяналт тавих цооног байгуулах, халианаас хамгаалах далан байгуулах шийдвэр гарсан. Уг шийдвэрийн дагуу Орчны бохирдол бууруулах Үндэсний хорооноос 100.0 сая төгрөгний санхүүжилт шийдвэрлэхээр болсон.

Мөн 50.0 сая төгрөгний санхүүжилтийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлүүлэхээр Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлж санхүүжилтийг Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсэн. Нийт 150.0 сая төгрөгний санхүүжилтээр “Шадар хэвтүүл” ХХК-тай Эрдэнэбулган сумын хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх, шинээр хогийн цэг байгуулах, хуучин хогийн цэгт техникийн нөхөн сэргээлт хийх, хяналтын цооног байгуулах гэрээ байгуулсан. Одоогоор ажлын явц 40 хувьтай явагдаж байна.

“Загасны үржлийн нүүдэл, түрс шахдаг газрыг тогтоох, зарим нууранд загас үржүүлэх боломж нөөцийг судлах хамгаалалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах” ажлын тендерийг үнэлж гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулсан. Гүйцэтгэгчээр Шинжлэх ухааны академийн геоэкологийн хүрээлэн шалгарсан.

Цагааннуур сумын загас үржүүлгийн цехэд үржил, судалгааны ажил, загас үржүүлгийн байр барих ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн хийж гүйцэтгэх ажлын тендерийг зарласан.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай аймгийн Засаг даргын албан даалгавар боловсруулж гаргуулав. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үнэлгээний хороо хуралдаж гүйцэтгэгчийг шалгаруулсан.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн 20 сая мод тарьж ургуулах ажлын 2022 оны төлөвлөгөөг гаргасан.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА